

2015 оны 03 сарын мэдээ

2015.04.02

Их Хүрэмт

Сумны бүх төр төсвийн байгууллагын хүрээнд нэг бүтэн улирал өнгөрч, улирлын ажил дүгнэх сар болж өнгөрлөө. 03 дугаар сарын сүүлийн 7 хоногийг тайлангийн долоо хоног болгон зарлалаа. Бүх дарга нар Орхон аймагт зохион байгуулагдсан “Булганыхан” уулзалтанд оролцохоор явсан, сургалт семинартай байсан тул хийж амжаагүй.

Улсын Их хурлын гишүүн Ё.Отгонбаяр 2015 оны 03 дугаар сарын 11-ний өдөр иргэд хөдөлмөрчидтэйгээ уулзалт зохион байгууллаа.



Ё.Отгонбаяр гишүүн иргэдэд өнөөгийн улс орны эдийн засгийн байдал, шинэчлэгдэн батлагдсан зарим хуулиуд, улсын их хурлын үйл ажиллагааны талаар товч танилцууж иргэдээс санал хүсэлтийг нь сонсож ажиллаа.

Уулзалтын үеэр нилээд хэдэн хүмүүсийг шагнаж урамшууллаа. Үүнд:

“Эрүүл мэндийн салбарын тэргүүний ажилтан” цол тэмдгээр “Сайхан-овоо” багийн бага эмч Цэцэгээ овогтой Одончимэг

“Боловсролын салбарын тэргүүний ажилтан” цол тэмдгээр “Насан туршийн боловсролын нэгжийн багш” Баасан овогтой Долгоржав

“Уул уурхайн салбарын тэргүүний ажилтан”-аар Сайхан-Овоо багийн иргэн Лувсан-Өлзий овогтой Цэцэгээ, Баянжаргал овогтой Тэрбиш,

“Боловсролын яамны хүндэт жуух бичиг”-ээр Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш Өлзийсайхан овогтой Золбоо

“Хүнс хөдөө аж ахуйн яамны жуух бичиг”-ээр Жамсранжав овогтой Энхбаатар нар болон “Атар газар эзэмшсний 55 жилийн ойн медаль”-аар 10 гаруй хүнийг шагнаж урамшууллаа.



Ирэх долоо хоногт Сайхан суманд анх удаа 108 шатарчдын тэмцээнийг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын “Шатар” дэд хөтөлбөр, Сумын Засаг даргын “Сайхан хамтын хөгжил” хөтөлбөрийн хүрээнд Сайхан сумын “Сайхан Ламаадан” шатрын клубын багш Э.Банзрагч, сумын ЗДТГазар хамтран сумандаа анх удаа 108 шатарчны тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.



Ивээн тэтгэгчээр 4-р багийн малчин А.Лхагвасүрэн, Сайхан сумын уугуул аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга Д.Гансүх нар оролцлоо.




Шатрын тэмцээнийг шатрын Олон улсын програмаар явуулж, Орхон аймгаас шатрын олон улсын шүүгч Баттулга урилгаар ирж ажилласан. Энэ тэмцээний онцлог маань хүүхэд, насанд хүрэгчид бүх хүмүүс яг ижил тоглож, манай сурагчид үнэхээр сайн байсныг тэмдэглэхэд таатай байна. Энэ нь манай суманд “Шатар” хөтөлбөр сайн хэрэгжиж байгаагийн нэг томоохон жишээ боллоо.

Нийт 108 шатарчнаас 33 оноогоор 9-р ангийн сурагч Ж. Жавьяндорж тэргүүн байр, 2-р байрыг Батбямба 31 оноогоор, 3-р байрыг Давааням





Орхон аймагт зохион байгуулагдсан “Булганыхан” уулзалт золголтонд Засаг дарга Н.Мэнд-Амар, ИТХ-ын дарга А.Бадамсүрэн, Засаг даргын орлогч Ч.Дэмбэрэлдорж, ЗДТГ-ын дарга С.Лувсанцоодол нар болон бусад нэр бүхий 10 гаруй хүн оролцоод ирлээ.



Энэ уулзалт ярилцлагын үеэр Сайхан нутгийн уугуул иргэдтэйгээ уулзаж 4 түмэн адууны баярын талаар санал солилцох уулзалт зохион байгуулсан. Баярыг хэрхэн зохион байгуулах сум орон нутагтаа бүтээлч ажил төрөл юу хийх саналтай байгаа талаар ярилцлаа.



ТАЙЛАН БИЧСЭН:



ТЗАХМ Н.ЮМЧИНРАГЧАА